“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар **№250**

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/20260602622
Төсөвт өртөг: 19,000,000 төгрөг

2026.10.15

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Acronis Cyber Protect Backup Advanced Server	шир	2.0	Acronis Cyber Protect Backup Advanced Server

ХИЙМЭЛ ОЮУН УХААНААР ҮНЭЛЭХ AI ТЕХНОЛОГИЙН КАМЕРТ СУУРИЛСАН ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зориулалт:

Камерт суурилсан хиймэл оюун ухааны программ хангамжийн боловсруулсан дүрс, үнэлгээний үр дүн, өгөгдлийн сан, холбогдох файл болон системийн тохиргоог автоматаар нөөцлөх, архивлах, шаардлагатай үед сэргээх замаар мэдээллийн бүрэн бүтэн байдал, системийн тасралтгүй ажиллагааг хангахад зориулагдана.

1. Нийлүүлэгчид тавигдах шаардлага:

- Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн шинэ, ашиглагдаагүй тоног төхөөрөмж нийлүүлнэ.

2. Системийн ерөнхий техникийн үзүүлэлт:

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага
1	Программ хангамж	**Acronis Cyber Protect Advanced Server эсхүл түүнтэй дүйцэх** серверийн нөөцлөлт, сэргээх программ хангамж
2	Тоо хэмжээ, лиценз	**2 серверийн лиценз**, ашиглах эрх, шинэчлэлт болон техникийн дэмжлэгийн хугацаа 36 **сараас доошгүй**
3	Хамрах хүрээ	Санхүүгийн **Microsoft SQL Server** болон ERP серверийн **MySQL өгөгдлийн сан, файл систем, үйлдлийн систем, программын тохиргоог** нөөцлөх
4	Нийцэл	Захиалагчийн ашиглаж буй Windows Server, MSSQL болон MySQL-ийн бодит хувилбарт нийцэх. ERP-ийн **MySQL 5.1–5.5** хувилбарыг шууд дэмжихгүй бол өгөгдлийн сангийн dump болон автомат скриптээр бүрэн нөөцлөх шийдлийг нийлүүлэх

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага
5	Нөөц хадгалах орчин	Захиалагчийн NAS төхөөрөмжийн сүлжээний хадгалалт руу нөөцлөх. Үндсэн нөөцлөлт, сэргээх ажиллагаа нь cloud хадгалалт шаардахгүй байх
6	Нөөцлөлтийн төрөл	Бүтэн болон өөрчлөлтийн нөөцлөлт; серверийг бүтнээр нь, өгөгдлийн санг болон файлыг тусад нь сэргээх боломжтой байх
7	Санхүүгийн өгөгдлийн сан	MSSQL-ийн ажиллагаатай үеийн өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг ханган нөөцлөх. Өдөр бүр автомат нөөц авч, сүүлийн **60 хоногийн** өдөр тутмын нөөцийг хадгалах
8	ERP өгөгдлийн сан	Өдөр бүр автомат нөөц авч, сүүлийн **60 хоногийн** өдөр тутмын нөөцийг хадгалах. Нөөц авах явцад өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг хангах
9	Сарын архив	Сар бүрийн **хамгийн сүүлийн амжилттай нөөцийг 24 сар** хадгалах. Өдөр тутмын бусад нөөцийг хугацаа дуусахад автоматаар цэвэрлэх. Архив нь сэргээхэд шаардлагатай бүх нөөцийн бүрэлдэхүүнийг хадгалсан байх
10	ERP файл систем	Хавсралт, зураг, баримт болон сонгосон хавтасны өөрчлөлтийг **15 минутаас ихгүй интервалаар** NAS руу автоматаар хуулж/нөөцлөх. Файлын өмнөх хувилбарыг **30 хоногоос доошгүй** хадгалах
11	Бааз, файлын уялдаа	ERP-ийн өгөгдлийн сан болон файл системийг уялдуулан нөөцөлж, сонгосон сэргээх цэгт хавсралтын бүртгэл болон холбогдох файлыг хамтад нь сэргээх зохицуулалттай байх
12	Серверийн системийн нөөц	Хоёр серверийн үйлдлийн систем, суулгасан программ, тохиргоог долоо хоног бүр нөөцлөх; сүүлийн **4 сэргээх цэгээс доошгүй** хадгалах
13	Нөөцийн хамгаалалт	Нөөцийн шифрлэлт, эрхийн хязгаарлалттай байх. Эх серверийн файл устсан, өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх сэргээх цэгүүд хадгалагдах. Нөөцийг устгах/өөрчлөхөөс хамгаалах боломжийг санал болгож, шаардагдах нэмэлт хадгалалтын нөхцөлийг тодорхой тусгах
14	Удирдлага, мэдэгдэл	Хоёр серверийн нөөцлөлтийг төвлөрүүлэн удирдах; хуваарь, хадгалах хугацааг тохируулах; амжилттай болон алдаатай ажиллагааны **имэйл мэдэгдэл**, журнал, тайлантай байх
15	Суурилуулалт	Лиценз идэвхжүүлэх, агент болон шаардлагатай нэмэлт хэрэгсэл суурилуулах, NAS холболт, нөөцлөлтийн хуваарь, сарын архив, ERP файлын хуулалтыг бүрэн тохируула
16	Хүлээн авах туршилт	MSSQL, MySQL баазыг тусдаа туршилтын орчинд сэргээж шалгах; ERP-ийн өмнөх хувилбарын файл сэргээх; серверийн системийн нөөцөөс сэргээх ажиллагааг турших, үр дүнг актаар баталгаажуулах

3. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

№	Нэр	Хэмжих нэгж	Тоо	Хугацаа
1	Програм	ширхэг	2	14 хоног

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг бараа нийлүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, бараа нийлүүлэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ
- Техникийн тодорхойлолт, танилцуулга, бусад нотлох баримт
- Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар

Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 17 цаг 00 минут хүртэл

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга болон үнийн санал хүлээн авах хаяг:
Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044